Завхан аймгийн засаг даргын А/273 дугаар захирамжаар хүчингүй болсон.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 4 дүгээр

сарын 30-ны өдөр Дугаар 80

Улиастай

РАШААНЫ ХАМГААЛАЛТ, ЭРҮҮЛ АХУЙН БҮС ТОГТООХ ТУХАЙ

Отгонтэнгэрийн халуун рашааны ордын байгалийн унаган төрхийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Усны тухай хуулийн 13.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 38.1, Ариун цэврийн тухай хуулийн 15.2.3 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг:Рашааны ордын хамгаалалтын бүсийг хойт талаараа Рашаант голын урдуур, рашааны хөлийн асганы захаар, Зүүн талаараа Цагаан товгорын Отгонтэнгэр уулын баримал, Анаг толгойн доод үзүүр, урд талаараа Ногоон байшинтын ам, Дамрын бөөрөг, баруун талаараа Дэрсэгийн бөөргийн доод үзүүрээр хязгаарлагдах бүгд 400 га талбайг хамруулан тогтоосугай.

Хоёр:Рашаан, ундны цэнгэг усны эх булгийг хамгаалах, эрүүл ахуйн бүсийг сувиллын конторын барилгаас эргэн тойронд 500 м радиустай талбайг хамруулан тогтоосугай.

Гурав. Рашааны ордын хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсэд мөрдөх дэглэмийг хавсралтаар баталсугай.

Рашааны ордны хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд мөрдөх дэглэмийн хэргэжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.БАТМӨНХ